

**Нийгмийн даатгалын ерөнхий газар**

**Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

**2021.01.14.**

№	Хөтөлбөрийн танилцуулга хэсэг		
1	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”	
2	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх	
3	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө	
4	Хэрэгжүүлэгч байгууллага	Бүх шатны төрийн байгууллага	
5	Хэрэгжих нийт хугацаа	6 жил	
<b>Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг</b>			<b>Үнэлгээ</b>
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөлөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр;			
4.1.1.1.1.	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох;	Төрийн албаны салбар зөвлөлөөс ирүүлсэн 2 албан хаагчийн дүгнэлт, АТГ-т хянуулсан 19 албан хаагчдын дүгнэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудасны Ил тод байдал цэсний Авлигын эсрэг үйл ажиллагаа хэсэгт орууллаа. Эдгээрээс 17 албан хаагч нь салбартаа ажиллаж байгаа албан хаагч бөгөөд албан тушаал шилжих, албан тушаал дэвших зэргээр ажлын байр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор АТГ-т ХАСУМ-ыг хянуулсан байна.	100%
4.1.1.1.5.	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн	Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн албан хаагчдын бүртгэлийг хөтөлж, төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн бүртгэлийн програмд тухай бүр мэдээллийг шинэчлэн оруулж ажиллаж байна.	92%

	албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн, төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох;		
4.1.1.2.1.	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх;	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 7 албан хаагчийг дэвшүүлэн томилсон байна. Тус байгууллагын ажилтнуудын 55.8% нь 3-аас дээш жил, 45,2% нь 10-аас дээш жил ажиллаж байгаа бөгөөд туршлага, ур чадварыг үндэслэн мерит зарчмаар 10 орчим хувийг дэвшүүлэн ажиллуулж байгаа болно.	100%
4.1.1.7.1.	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;	Иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх санал хүсэлтийг: <ol style="list-style-type: none"> <li>1. <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> цахим хуудас,</li> <li>2. 77771289 лавлах утас,</li> <li>3. Зөвлөгөө мэдээллийн Facebook хуудас,</li> <li>4. “Нийгмийн даатгал” гар утасны аппликейшн, бичгээр,</li> <li>5. Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан хүлээн авч байна.</li> </ol> Тайлант хугацаанд: <ol style="list-style-type: none"> <li>1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын <a href="http://www.ndaatgal.mn">www.ndaatgal.mn</a> вэбсайтын “Санал хүсэлт” буланд иргэд-даатгуулагчаас 630 санал хүсэлт, асуулт ирүүлж, хариултыг тухай бүрхүргэн ажилласан байна.</li> <li>2. Нийгмийн даатгалын лавлах 7777-1289 дугаар утсанд орж ирсэн дуудлагаас нийтдээ 57602 нь дуудлаганд хариу өгч ажилласан.</li> <li>3. Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын талаарх мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор facebook хуудсыг 2020 оны 01 дүгээр сараас ажиллуулж эхэлсэн бөгөөд энэ хуудсаар дамжуулан нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд ойлгомжтой, хялбар байдлаар хүргэхийн тулд зурган хэлбэрээр байршуулах, иргэдийн бичсэн сэтгэгдэлд хариу өгөх, зурвасаар харилцан зөвлөгөө өгөх, “нийгмийн даатгал” аппликейшн суулгах, ашиглах заавар өгөх, баталгаажуулах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах зэрэг үйлчилгээг үзүүлэв.</li> <li>-Facebook хуудсанд хандалт хийсэн иргэдийн дийлэнх нь 25-44 насныхан байгаа бөгөөд мэдээлэл авсан нийт иргэдийн 82 хувь нь буюу 12351 нь эмэгтэй, 18 хувь нь буюу 2711 нь эрэгтэй хүмүүс байна. Гадаад оронд ажиллаж амьдарч байгаа иргэд мөн холбогдох мэдээлэл, зөвлөгөө авч байгаагаас БНСУ-аас 197, Япон улсаас 39, АНУ-аас 20, Австрали улсаас 12, Бүгд найрамдах Чех улсаас 12, Шведээс 11, Туркээс 9, Францаас 7, БНХАУ-аас 7 иргэн холбогдсон байна.</li> <li>4. “Нийгмийн даатгал” аппликейшнээр 3588 санал хүсэлт ирсэнийг ажлын 5 хоногт багтаан</li> </ol>	95%

		хариуг иргэд, даатгуулагчид утсаар болон и-мэйл хаягаар нь хүргүүлж ажиллалаа. /нийт 1535/ 5. Мөн иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн 133 асуултын хариуг иргэдтэй нь утсаар холбогдон цаг тухайд нь өгсөн.	
4.1.1.9.1	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох;	Цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Салбарын хэмжээнд анхан шатны баримтыг цахимжуулах ажлын хүрээнд веб технологид суурилсан “Цахим архивын програм хангамж”-ийг 2019 онд нэвтрүүлсэн. Энэхүү програм хангамж нь бүх төрлийн архивын мэдээлэл /metadata/-ийг гараас оруулах боломжтой тул анхан шатны баримтыг стандартын дагуу цахим хэлбэрт шилжүүлэх бүрэн боломжтой. Мөн хайлтын системтэй ба OCR танигчтай. Мэдээллийн санг Мэдээллийн технологийн төвийн сервер компьютерт хадгалдаг. Мөн Байгууллагын удирдлагын цогц програм хангамж болох Able програмыг 2018 оноос эхлэн салбарын хэмжээнд хэрэглэж, албан бичиг, тушаал шийдвэр, чиглэл зэргийг цахимаар явуулж хэвшээд байна. 2020 8-р сараас төрийн албаны цалингийн нэгдсэн системд холбогдож, албан хаагчдын цалинг олгож байна. НДЕГ-ын архивт хадгалагдаж буй цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Үүнд: НДЕГ-ын 1991-2019 оны захирамжлалын баримт бичиг болох газрын даргын тушаалуудыг PDF файлаас зурган файлд хөрвүүлж цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн	95%
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр;			
4.1.2.1.1.	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах;	<b>2020 онд шинээр 5 програм хангамж боловсруулан нэвтрүүллээ. Үүнд:</b> 1. “Нөхөн даатгал 2020” вэб програм: Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 483 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дагуу 1995-2019 оныг дуусталх хугацааны нөхөн даатгалд хамрагдах малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний мэдээллийг бүртгэх, нөхөн төлөх шимтгэлийг тооцох, нөхөн төлөх хүсэлт болон баталгаажилтын хуудас хэвлэх зориулалт бүхий програм; 2. “Сайн дурын даатгуулагч эх-HYBRID” вэб програм: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 485 тоот тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/11 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхдээ 3 нас хүртэл асрах чөлөөтэй байгаа эхийн сайн дурын даатгалыг бүртгэх зориулалт бүхий програм; 3. “Сайн дурын даатгалын онлайн систем”: Энэхүү систем нь иргэд даатгуулагчдад зориулсан сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, төлбөр төлөх үйлчилгээг цахимаар үзүүлэх “Даатгуулагчид зориулсан онлайн систем”, нийгмийн даатгалын байцаагч ажилтнууд холбогдон ажиллах “Байцаагчид зориулсан систем”-ээс тус тус бүрдсэн. Уг системүүдийг нэвтрүүлснээр иргэд сайн дурын даатгалын үйлчилгээг түргэн шуурхай авах, мөн байцаагчийн ажлын ачаалал эрс буурах	93%

		<p>давуу талуудтай. Тухайлбал:          Даатгуулагч нийгмийн даатгалын байгууллагад өөрийн биеэр ирэхгүйгээр:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Гэрээний заалтуудтай танилцах;</li> <li>• Гэрээний хугацаа, шимтгэл төлөх сарын хөдөлмөрийн хөлс, орлогын хэмжээ, ажил эрхлэлтийн байдлаа өөрөө тодорхойлж оруулах;</li> <li>• Шимтгэлийн төлбөрөө QPay, Sendly зэрэг төлбөр төлөлтийн хэлбэр ашиглан онлайнаар төлөх;</li> <li>• Гэрээний нөхцөлүүдээ зөвшөөрч хүсэлт илгээх;</li> <li>• Гэрээгээ сунгуулах, шилжилт хөдөлгөөн хийх хүсэлтээ илгээх;</li> <li>• Шимтгэл төлөлтийн мэдээлээ харах, хянах боломжтой.</li> </ul> <p>2020 оны 8 дугаар сараас эхлэн нэвтрүүлсэн уг системүүдэд одоогийн байдлаар 964 даатгуулагч онлайнаар сайн дурын даатгалд хамрагдсан байна.</p> <p>4. Мөн сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, төлбөр төлөх үйлчилгээг нийгмийн даатгалын байгууллагад өөрийн биеэр ирэхгүйгээр гар утаснаасаа “Нийгмийн даатгал” аппликейшнээр авах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>5. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн хүрээнд нийгмийн даатгалын салбарын хэмжээнд цаасан хэлбэрээр хадгалагдан ашиглагдаж байсан 1995-2005 оны НД-7, НД-8 тайлангуудыг цахим хэлбэрт шилжүүлэх ажил хийгдсэн. Үүнтэй уялдан даатгуулагчдын тухайн онуудын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг цахимд суурилан гаргах зориулалт бүхий “Цахим архивын лавлагаа” програм хангамжийг нэвтрүүлсэн. Даатгуулагчийг аймаг, сум, дүүрэг хооронд явуулж чирэгдэл учруулахгүйгээр тухайн нэгжийн архивын ажилтан шууд хэвлэж өгөх боломж бүрдэж байгаа юм.</p>	
4.1.2.1.2.	Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх;	<p><b>Төрийн байгууллагатай цахимаар мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлсэн байна.</b>          Тухайлбал:</p> <p>1. Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газартай байгуулсан “Мэдээлэл солилцох гэрээ”-нд 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулан 11 төрлийн мэдээлийг тус газарт цахимаар хүргүүлэн ажиллаж байна.</p> <p>2. Улсын бүртгэлийн ерөнхий газартай байгуулсан “Мэдээлэл солилцох гэрээ”-ний дагуу хуулийн этгээдийн бүртгэлийн 6, иргэний бүртгэлийн 3 төрлийн мэдээллийг цахимаар авч ажиллаж байна.</p> <p>3. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээг шинэчлэн байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу эрүүл мэндийн даатгалтай холбоотой 9 төрлийн мэдээллийг цахимаар солилцон ажиллаж байна.</p> <p>4. Төрийн байгууллагуудтай цахимаар мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлж Сангийн яамнаас болон Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газраас олгодог тусгай зөвшөөрөл авах аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой 3 оролт, 5 гаралт мэдээллийг цахимаар өгөх боломжийг бүрдүүлээд байна.</p>	95%

		<p>5. Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам” болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг үндэслэн Үндэсний статистикийн хороотой хамтран ажиллах гэрээ байгуулан нийт 30 оролт, 150 гаралт бүхий ажил олгогч, албан журам болон сайн дурын даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчдын мэдээллийг цахимаар өгөхөөр сервис боловсруулаад байна.</p> <p>6. Төрийн нэгдсэн үйлчилгээний “ХУР” системээр дамжуулан мэдээлэл солилцох ажлын хүрээнд ЭМЯ, ЭМДЕГ, Сангийн яам, БХБЯ, ЭХЯ, БШУЯ, ТатЕГ, ХХҮЕГ, ШШГЕГ, АТГ, ТагЕГ, АТҮТ, ЦЕГ төрийн байгууллагыг цахим мэдээллээр тогтмол ханган ажиллалаа.</p> <p style="text-align: center;"><b>Иргэд, даатгуулагчдад цахимаар 4 сувгаар мэдээлэл хүргэлээ.</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төв орон нутгийн нийгмийн даатгалын 30 нэгжийн мэдээллийн санг өдөр тутам цуглуулан нэгтгэж Үндэсний Дата Төв, төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогчийг цахим мэдээллээр тогтмол хангалаа. Тухайлбал:</li> <li>2. Иргэд даатгуулагчид 2006 оноос хойших шимтгэл төлөлт, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэл, тэтгэмжийн зардал авалтын сүүлийн 1 жилийн, тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолтын мэдээлэл, цалин, тэтгэврийн түүх болон тэтгэвэр олголтын мэдээлэл, мөн НДХ-ийн хаяг байршил, утасны дугаар, хууль тогтоомж, бусад мэдээ мэдээллийг харах зориулалт бүхий "Нийгмийн даатгал" гар утасны аппликейшнийг 121.0 мянган даатгуулагч идэвхтэй ашиглаж байна.</li> <li>3. Иргэд даатгуулагчид 2006 оноос хойших шимтгэл төлөлт, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэл, тэтгэмжийн зардал авалтын сүүлийн 1 жилийн, тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолтын мэдээлэл, цалин, тэтгэврийн түүх болон тэтгэвэр олголтын мэдээллээ интернэтээс харах, хэвлэн авах боломж бүхий “Даатгуулагчид зориулсан вэб” програм хангамжид 261.0 мянган удаагийн хандалт хийгдсэн.</li> <li>4. Улсын хэмжээнд ашиглагдаж буй 109 ТҮЦ машинаас нийгмийн даатгалын үйлчилгээний 4 төрлийн 180.0 мянга орчим лавлагаа тодорхойлолтыг хэвлэн авсан.</li> <li>5. Монгол улсын Засгийн Газраас иргэд, бизнес эрхлэгчдийн авдаг төрийн үйлчилгээг хүртээмжтэй, түргэн шуурхай, чирэгдэлгүй, ил тод хүргэх зорилгоор төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр, нэг цонхоор хүргэх зориулалт бүхий e-mongolia цахим порталаар нийгмийн даатгалын 3 төрлийн лавлагаа тодорхойлолтыг авах боломжийг бүрдүүлсэн.</li> </ol> <p style="text-align: center;"><b>Төрийн мэдээлэл солилцооны ХУР системийн бусад хандалтын талаар</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Ажил олгогчийн "Шимтгэлийн цахим систем"-ийн хандалт 529.1 мянга.</li> <li>2. QR кодтой лавлагаа тодорхойлолтоо хэвлэн авсан 92.4 мянган иргэд даатгуулагч, 22.7 мянган ажил олгогч</li> <li>3. QR кодтой лавлагаа тодорхойлолтыг шалгах вэб програм хангамжаар 62.6 мянган даатгуулагч, 11.0 мянган ажил олгогчийн лавлагаа тодорхойлолтыг шалгасан.</li> <li>4. Хур систем, ТҮЦ, Төрийн нэг цэгийн үйлчилгээний төв, НДХ-үүдэд хэвлэдэг лавлагаа болон бусад хандалтын тоо 5423.1 мянга</li> </ol>	
--	--	---	--

		Сервисээр мэдээлэл солилцдог ШШГЕГ, ТагЕГ, ХХҮЕГ, АТГ, ЭМЯ зэрэг төрийн байгууллагуудын сервисийн хандалт 2797.7 мянгад хүрсэн байна.	
4.1.2.4.3.	Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх;	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/67 дугаар тушаалаар байгуулагдсан “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг зохион байгуулах” журмын төсөл боловсруулах ажлын хэсэг 5 удаа хуралдаж, хурлаас гарсан шийдвэр болон газар, хэлтсүүдээс гарсан санал, сургалт зөвлөгөөнөөс гарсан шийдвэрийг нэгтгэж журмын төслийг боловсруулсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын талаар сургалт зохион байгуулж сургалтанд давхардсан тоогоор ХШГ, ДАМГ-ын 48 байцаагч, ажилтан хамрагдсан.</li> <li>• Татварын Ерөнхий газарт албан бичиг хүргүүлж тус газрын Эрсдэлийн удирдлагын газартай танилцан Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлж байгаа байдлаар туршлага судлан цаашид хамтран ажиллах ажлын хэсэг байгуулж мэдээлэл солилцон ажиллаж байна.</li> <li>• “IT ZONE” ХХК-иас “Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх, нэвтрүүлэх” төслийн ажлын хүрээнд “Зөрчил” дэд системийн хөгжүүлэлтэд саналаа хүргүүлж ажилласан. Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>1. Хяналт, шалгалтын үйл ажиллагааны талаарх системийн загварчлал хүргүүлж анхны туршилтын ажил хийгдсэн.</li> <li>2. Хяналт шалгалтын тайланг програмчлах тайлангийн загварыг тус тус хүргүүлсэн.</li> </ol> <p>Энэхүү системийг нэвтрүүлсэнээр Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналтыг сайжруулах, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал олгоход учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэж хамгийн их эрсдэлтэй гэж үзсэн ажил, үйлчилгээнд урьдчилсан байдлаар заавар, зөвлөмж хүргүүлж ажиллах юм.</p> </li> </ul>	98%
4.1.2.7.1.	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх;	<p>НДЕГ-ын даргын 2015 оны А/172 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгаа авах журам”-ыг шинэчлэх ажлын хүрээнд Сэтгэл ханамжийн судалгаа авах журмын төслийг боловсруулсан. Уг журмаар сэтгэл ханамжийн судалгаа авах арга хэлбэр, судалгааны төрлүүдийн нарийн дурьдсан болно.</p> <p>2019 онд сэтгэл ханамжийн судалгаа авах арга хэмжээг 3 удаа зохион байгуулсан ба 2020 онд авах сэтгэл ханамжийн судалгаа нь Ковид-19 цар, тахлын улмаас хойшлогдсон болно. Харин цахим хэлбэрээр санал, хүсэлт, өргөдөл гомдлыг хүлээн авч тухай бүр хариу өгч ажиллаж байна.</p>	Үнэлэх боломжгүй
Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвхи санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр;			
4.1.7.1.1.	Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх;	Тус байгууллагад 2019 оны “Шударга байдлын үнэлгээ”-г “Эм Эм Си Жи” ХХК хөндлөнгийн байдлаар хийж гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээ хийхэд дэмжлэг туслалцаа үзүүлж, нөхцөл бололцоогоор ханган ажилласан.	Үнэлэх боломжгүй

Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр			
4.1.10.1.4.	Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах;	<p>Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /газар/-ийн дарга нарт Авлигын эсрэг хуулийн 6, 7 дугаар зүйлд заасан авлигаас урьдчилан сэргийлэх болон хуулиар хориглосон үйл ажиллагааг нэг мөр хэрэгжүүлж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7, 9 дүгээр зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг биелүүлж, үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллах чиглэл болон 2020 оны 04 сарын 02-ны өдрийн 8/615 дугаартай зөвлөмжийг тус тус өгсөн.</p> <p>Авлигын гэмт хэргээс урьчилан сэргийлэх чиглэлээр 20 гаруй мэдээ мэдээлэл, аудио хичээл, видео шторкийг нийт албан хаагчдад тухай бүр Able програмын Олон нийт цэс, байгууллагын цахим хуудсаар дамжуулан хүргэж байна. Мөн байгууллагын Ёс зүйн зөвлөлөөс “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан ёс зүйн хэм хэмжээний талаарх эмхэтгэл” хэвлүүлэн, салбарын албан хаагчдад хүргүүлж, ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, зөрчил гарахаас урьчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан.</p> <p>Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр шинэ төрлийн коронавирус (2019-nCoV)-ийн халдвар тархахаас урьдчилан сэргийлж, сургалт, олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг түр хугацаагаар хязгаарлан өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотойгоор цахим хуудас дотоод сүлжээгээр мэдээ мэдээлэл, шторк, аудио зөвлөмжүүдийг нийт 20 гаруй удаа хүргэн ажилласан.</p>	95%
<b>Дундаж үнэлгээ</b>			<b>95,9%</b>